



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх эко тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/154/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүү аудитын аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugsss@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Azure хүлүг худит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 522
танай _____ -ны № _____ -т

БАЯНЗҮРХ ЭКО ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙДЭМБЭРЭЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх эко тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төлөвлөсөн орлогыг 7.7 хувиар давуулан биелүүлж 16,881.2 сая төгрөг оруулсан байна.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Нийслэлийн засаг даргын 2025 оны А/1262 дугаар захирамжаар 1,941.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1426050437

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 78 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,598,901,456.84	79,102,004.81
1.1.02	Дансны авлага	72,437,840.00	26,026,260.84
1.1.06	Бараа материал	551,302,808.52	433,901,497.35
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,250,000.00	333,664,132.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,227,892,105.36	872,693,895.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	4,901,156,800.29	6,374,094,936.74
1.2.02	Биет бус хөрөнгө	28,446,666.67	350,247,984.95
1.2.09	Дуусаагүй барилга	88,016,493.80	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,017,619,960.76	6,724,342,921.69
1.3	Нийт хөрөнгийн дүн	7,245,512,066.12	7,597,036,816.69
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.01	Дансны өглөг	1,166,857,682.71	46,977,331.00
2.1.1.03	Татварын өр	48,490,765.06	50,075,882.02
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	4,616,844,131.95	5,610,987,360.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,832,192,579.72	5,708,040,573.21
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,832,192,579.72	5,708,040,573.21
2.3.02	- хувийн	20,000.00	20,000.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	65,047,000.00	65,047,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,348,252,486.40	1,823,929,243.74
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	449,157,514.73
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,348,252,486.40	1,374,771,729.01
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,413,319,486.40	1,888,996,243.74
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	7,245,512,066.12	7,597,036,816.95

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	18,487,891,021.40	15,879,331,535.06
2	Борлуулалтын өртөг	-	15,153,469,064.95
3	Нийт ашиг(алдагдал)	18,487,891,021.40	725,862,470.11
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	10,536,273.30	13,427,877.83
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	824,320,665.29	988,429,023.62
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	17,676,740,456.58	1,184,715,496.49
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,161,189,852.86	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны(гарз)	-	(43,939,970.07)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг	90,000.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	484,907,650.55	499,063,905.00
19	Орлогын татварын зардал	48,490,765.06	49,906,390.53
20	Татварын дараах ашиг	436,416,885.49	449,157,514.47
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг	436,416,885.49	449,157,514.47

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	20,000.00	-	1,025,183,601.15	1,025,203,601.15
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(113,348,000.00)	(113,348,000.00)
Залруулсан үлдэгдэл	20,000.00	-	911,835,601.15	911,855,601.15
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	436,416,885.25	436,416,885.25
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	65,047,000.00	-	65,047,000.00
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	20,000.00	65,047,000.00	1,348,252,486.40	1,413,319,486.40
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	26,519,242.61	26,519,242.61
Залруулсан үлдэгдэл	20,000.00	65,047,000.00	1,374,771,729.01	1,439,838,729.01
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	449,157,514.73	449,157,514.73
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	20,000.00	65,047,000.00	1,823,929,243.74	1,888,996,243.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,903,743,643.88	15,301,755,319.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,837,026,279.00	15,235,834,895.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	16,155,341.00	24,870,946.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	50,562,023.88	41,049,478.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,687,975,590.81	16,460,483,439.87
1.2.1	Ажиллагчдад төлсөн	7,947,791,066.83	8,042,047,300.21
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,206,089,363.74	2,170,434,811.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,109,105,571.46	3,339,740,267.35
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	205,836,065.68	219,584,463.23
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,111,405,294.20	988,245,116.93
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	335,883,544.49	62,493,342.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	71,866,528.80	100,979,833.93
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,699,998,155.61	1,536,958,304.14
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,215,768,053.07	(1,158,728,120.03)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	326,604,528.00	361,071,332.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	326,604,528.00	27,407,200.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	333,664,132.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(326,604,528.00)	(361,071,332.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	889,163,525.07	(1,519,799,452.03)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	709,737,931.77	1,598,901,456.84
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,598,901,456.84	79,102,004.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2025 оны		Төлөвлөгөөнөөс	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1	Орлого				
	2025 онд хийгдэх ажлууд				
1.1	Орон нутгийн санхүүжилт	-	-	-	-
1.2	Баянзүрх дүүргийн ОНХөгжлийн сан	15,103,044.9	15,103,044.9	-	100.0
1.3	Баянзүрх дүүргийн ОНХөгжлийн сан	64,000.0	64,000.0	-	100.0
1.4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	500,000.0	962,404.8	(462,404.8)	192.5
1.5	Үйл ажиллагааны бусад орлого	-	751,738.8	(751,738.8)	-
	Нийт орлогын дүн	15,667,044.9	16,881,188.4	(1,214,143.5)	107.7
2	Зардал				
2.1	Цалин	7,791,371.7	6,908,306.4	883,065.3	88.7
2.2	Хоол унааны нэмэгдэл	1,209,163.2	946,380.0	262,783.2	78.3
2.3	Нийгмийн даатгалын шимтгэл	1,305,077.6	2,170,434.8	(865,357.2)	166.3
2.4	Гэрэл цахилгааны зардал	110,000.0	110,628.6	(628.6)	100.6
2.5	Түлш халаалтын зардал	8,000.0	7,859.5	140.5	98.2
2.6	Цэвэр, бохир усны зардал	14,000.0	12,790.8	1,209.2	91.4
2.7	Байрны түрээсийн зардал	100,540.0	104,084.0	(3,544.0)	103.5
2.8	Бичиг хэргийн зардал	7,000.0	8,431.3	(1,431.3)	120.4
2.9	Тээвэр, шатахууны зардал	901,600.0	729,721.2	171,878.8	80.9
2.10.	Шуудан холбоо, интернэтийн зардал	5,000.0	4,449.7	550.3	89.0
2.11	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалын зардал	62,000.0	44,496.0	17,504.0	71.8
2.12	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	2,238,498.9	2,400,627.7	(162,128.8)	107.2
2.13	Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал	160,000.0	153,197.9	6,802.1	95.7
2.14	Багаж техник, хэрэгслийн зардал	188,093.6	271,705.7	(83,612.2)	144.5
2.15	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зардал	275,000.0	457,712.5	(182,712.5)	166.4
2.16	Урсгал засварын зардал	350,000.0	316,301.5	33,698.5	90.4
2.18	Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал	58,000.0	702,384.4	(644,384.4)	1,211.0
2.19	Аудит зэрэглэл тогтоох зардал	7,000.0	7,000.0	-	100.0
2.20.	Даатгалын үйлчилгээний зардал	100,000.0	100,979.8	(979.8)	101.0
2.21	Тээврийн хэрэгслийн татварын зардал	65,000.0	14,002.6	50,997.4	21.5
2.22	Тээврийн хэрэгслийн оношилгооны зардал	1,500.0	561.0	939.0	37.4
2.23	Мэдээллийн технологийн үйлчилгээний зардал.	4,000.0	3,655.0	345.0	-
	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	329.5	(329.5)	-
	Бусад хөрөнгө:	-	27,407.2	(27,407.2)	-
2.24	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	500,000.0	653,880.7	(153,880.7)	-
	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	27,565.2	(27,565.2)	-
2.25	Тэтгэвэрт, гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,200.0	25,024.6	21,175.4	54.2

Баянзүрх эко тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

2.26	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	75,000.0	61,927.0	13,073.0	82.6
2.27	Үйл ажиллагааны зардлын дүн	15,582,044.9	16,271,844.6	(689,799.7)	104.4
2.28	Бусад зардал	85,000.0	110,280.0	(25,280.0)	129.7
	Нийт зардлын дүн	15,667,044.9	16,382,124.5	(715,079.6)	104.6
3	Татварын өмнөх ашиг	-	499,063.9	(499,063.9)	100.0
4	Орлогын татвар	-	49,906.4	(49,906.4)	100.0
5	Цэвэр ашиг, алдагдал	-	449,157.5	(449,157.5)	100.0
6	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	-	-	-	-
7	Нийт авлага	-	26,026.3	(26,026.3)	-
8	Нийт өглөг	-	47,146.8	(47,146.8)	-
9	Нийт хөрөнгө оруулалт	-	27,407.2	(27,407.2)	-
10	Орон тоо	204	204	-	100.0
11	Дундаж цалин	3,150.6	3,068.4	82.2	97.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 147,906.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 147,906.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 562,974.5 мянган төгрөгийн 118 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд заасан шууд худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 147,906.2 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.	1	147,906.2	-	-	1	147,906.2	-	-	-	-	-	-	-
Дүн	2	147,906.2	-	-	1	147,906.2	1	-	-	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.